



ЗАХ ЗЭЭЛ

МАКРО ЭДИЙН ЗАСАГ | LEND.MN | ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА | БОНДЫН МЭДЭЭ | TOP 20 MSE ALL INDEX | КОМПАНИЙН БОНД

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.02.12- 02.15

АРИЛЖААНЫ ТОВЧ МЭДЭЭ

Өнгөрсөн 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 45 компанийн 1 тэрбум төгрөгөөр 1,002,134 ширхэг хувьцаа нийт 861 удаагийн хэлцлээр арилжигдав.

“Хүннү менежмент” /HBZ/ компанийн хувьцаа 14.98%-иар буюу хамгийн ихээр өсч 46.66 төгрөгт хүрч хаагдсан бол “Ган хийц” /GHC/ компанийн хувьцаа 14.31%-иар буурч 11,140 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн 2-р сарын 12-с 2-р сарын 15-ны хооронд ЗГҮЦ-ын анхдагч зах зээлд арилжаа хийгдээгүй.


ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн хувьд 13 удаагийн арилжаагаар 4,936 ширхэг үнэт цаас 513,020,100 сая төгрөгөөр арилжигдав.

Харин компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр энэ долоо хоногт арилжаалагдаагүй.

2-р сарын 15-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,580 их наяд төгрөгт хүрсэн бол MSE ALL индекс 1,194 нэгж болж 2.68 %-иар өссөн байна.



/Сүүлийн 5 хоногийн байдлаар харуулав/ Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн
Арилжигдсан үнийн дүн	1,004,135,548
Зах зээлийн үнэлгээ	2,580,001,632,863

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,642.79	1.49% ▲
MSE ALL	1,194.18	2.68% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн
Таван толгой	13,671	156,312,990
УБ-Бүк	226,659	95,082,420
Апу	120,908	84,578,059
Говь	1,816	42,281,500
Айтүүлс	186,839	27,572,403

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт	Өөрчлөлт
Хүннү менежмент	46.66	14.98% ▲
МИК	11.400	13.43% ▲
Таван толгой	11.450	11.60% ▲
Э-транс ложистикс	100	8.70% ▲
Монгол савхи	1.047	8.69% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт	Өөрчлөлт
Ган хийц	11,140	14.31% ▼
Монгол шилтгээн	400	14.09% ▼
Ноён хайрхан	1,150	11.54% ▼
Материал импекс	9,520	10.69% ▼
Багануур	2,000	9.09% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Ширхэг	Үнийн дүн
Тулгат чандмань баян ҮЦК	441,539	188,508,227
Голомт капитал ҮЦК	226,801	138,645,056
БиДиСек ҮЦК	202,652	124,748,484
Ард капитал групп ҮЦК	243,440	98,427,186
Бумбат-Алтай ҮЦК	82,883	85,135,905

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт	ЗЗҮ /сая.төг/
Апу	700.44	745,395
Таван толгой	11,800	621,449
МИК	11,400	236,086
Говь	24,000	187,227
Сүү	240.05	82,577

ӨНГӨРСӨН 7 ХОНОГИЙН ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	7 хоног	Хүү %
---	-----------------	--------------------	-----------	-----	---------	-------

-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	7 хоног	Хүү %
1	Z GEB-BD-04/07/19-A0266-14	20	2,095,200	104,760	104	14.820%
2	Z GEB-BL-09/05/19-A0242-16	1,000	100,000,000	100,000	104	15.995%
3	Z GEB-BD-10/10/19-A0336-14	546	56,947,800	104,300	104	13.945%
4	Z GEB-BD-11/04/19-A0230-18	70	7,515,900	107,370	104	18.000%
	Z GEB-BD-17/01/19-A0196-18	200	21,192,000	105,960	104	18.000%
	Z GEB-BD-24/10/19-A0348-14	140	14,616,000	104,400	104	13.955%

ӨНГӨРСӨН 7 ХОНОГИЙН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА / ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ /

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	7 хоног	Хүү %
---	-----------------	--------------------	-----------	-----	---------	-------

-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Ногдол ашиг/төгрөг/	Бүртгэлийн өдөр
1	TCK	Талх чихэр ХК	170	2018.04.06
2	MMX	Мах импекс ХК	100	2018.04.05
3	MNP	Монгол шуудан ХК	2.74	2018.02.13
4	ADL	Адуун чулуун ХК	130	2018.02.07
5	ТАН	Тахько ХК	108	2018.02.05
6	UBH	Улаанбаатар хивс ХК	100	2018.02.26
7	GOV	Говь ХК	220	2018.02.02



2017 онд компаниуд хэр хэмжээний ашигтай ажилласан бэ?

- Айтүүлс ХК 2017 онд 1.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ

Өнгөрсөн онд амжилттай IPO хийсэн Айтүүлс ХК 2017 онд 1.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийж (өмнөх оноос 2.8 дахин өссөн) орлогын татварт 7 сая төгрөг төлж тайлант хугацаанд 63 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Анх нэгж хувьцаагаа 100 төгрөгний нэрлэсэн үнээр анхдагч зах зээлд гаргаж байсан уг компанийн хувьцаа 2018.02.14-ний байдлаар 155.59 төгрөгөөр буюу 56% хувийн өсөлттэй арилжигдсан байна.

- Таван толгой ХК 141 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Таван толгой ХК (Олон нийтийн хэлж заншсанаар жижиг Таван толгой буюу орон нутгийн өмчит компани) -ийн 2017 оны санхүүгийн тайлан гарчээ.

Компани өнгөрөгч онд 428 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон нь 2016 оныхоос 2.4 дахин өссөн үзүүлэлт юм. Харин Орлогын татварт 48 тэрбум төгрөг төлж тайлант хугацаанд нийтдээ 141 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. 2016 онд компани нийт ашгийнхаа 85 хувийг (45.9 тэрбум төгрөг, нэгж хувьцаанд 872 төгрөг) ногдол ашиг хэлбэрээр тарааж байсан. Харин 2017 оны ашгаас хэчнээнийг ногдол ашиг хэлбэрээр тарааж нь сонирхол татаж байна.

Нэмж хэлэхэд 2011 онд тус компанийн хөрөнгийн бирж дээрх үнэлгээ 569 тэрбум төгрөгт хүрч нэг ширхэг хувьцааны үнэ 1.4 сая төгрөгөөр арилжаалагдан, нэг ширхэг хувьцаандаа 130,000 төгрөгийн ногдол ашиг тарааж Монголын хөрөнгийн биржийн түүхэнд дээд амжилтыг тогтоож байсан юм.

- Талх чихэр ХК, Монголын цахилгаан холбоо болон Мах импекс ХК-ын хувьд

"Талх Чихэр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 170.00 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг бүртгэлийн өдөр болох 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөр тогтоож 2018 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн бэлнээр компанийн байран дээр олгохоор шийдвэрлэсэн байна. Тус компани 2017 онд 1.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд нийт ашгийнхаа 15 хувийг (174 сая төгрөг) ногдол ашиг болгож тараах боллоо.

"Махимпекс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 100.00 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоож 2018 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн бэлнээр компанийн байран дээр олгохоор шийдвэрлэсэн байна. Тус компани 2017 онд 355 сая төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд жилийн ашгаасаа давсан хэмжээний (380 сая төгрөг) ногдол ашиг тараах боллоо.

"Монголын цахилгаан холбоо" компани 2017 онд зургаан сая төгрөгийн ашигтай ажиллалаа. Санхүүгийн үзүүлэлтүүдийг харвал жилийн турш 17.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 20.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Ингэснээр борлуулалтын ашиг болох 2.9 тэрбум төгрөг, хүүгийн орлогоос нэг тэрбум төгрөг олсон байна.

"ЛЭНДМН ББСБ" ХК: Хувьцаа сонирхож буй хөрөнгө оруулагчдын идэвхи өндөр байна

"Лэндмн" компанийн хувьцааг сонирхож байгаа хөрөнгө оруулагчдын идэвх өндөр байгааг компани онцоллоо. Өнөөдөр тус компани үнэт цаасны танилцуулгаа олон нийтэд нээлттэй зохион байгуулж, 580 орчим хүн оролцсон байна. Бичил хэрэглээний зээлийн хувьд зах зээлийн багтаамж дунджаар 900 тэрбум төгрөг гэж "Мирэ Эссет Секьюритис" үнэт цаасны компани тооцоолсон байна. Харин "Лэндмн"компани 2018 онд 196 тэрбум төгрөгийн зээл олгож, 20 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байхаар төлөвлөж байгаа юм. Компанийн хувьцааны захиалга энэ сарын 21-ээс гуравдугаар сарын 7 хүртэл үргэлжилнэ гэж андеррайтер компани нь мэдээлсэн. Хувьцааны захиалгыг гар утаснаасаа хийх боломжтой гэдгээрээ өмнө нь гарч байсан IPO-үүдээс онцлогтой юм.



Эх сурвалж: BloombergTV.mn

"CHINA SHENHUA"-ийн нүүрсний борлуулалт 6 хувиар өсчээ

Хонгконгийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "China Shenhua" компанийн нүүрсний гарц нэгдүгээр сард 3.5 хувиар, нүүрсний борлуулалт зургаан хувиар өсөж, 35.1 сая тоннд хүрчээ.

Ерөнхийдөө цаашид нүүрсээр ашигладаг Дулааны цахилгаан станцууд тасралтгүй буурна гэсэн тооцоог "Bloomberg Intelligence"-ийн шинжээчид гаргасан байна.



Ялангуяа Азийн бусад улсуудтай харьцуулахад БНХАУ-д бууралтын хурд өндөр байхаар байгаа юм. Азийн улсуудад эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 2040 он гэхэд 3946 гигаваттаар нэмэгдэхээр байгаа бөгөөд үүнээс дийлэнх буюу 98 хувийг цэвэр эрчим хүчний эх үүсвэрээс гарган авна гэдгийг "Bloomberg New Energy Finance" урьдчилан таамаглаж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.